**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 11 сарын 06 өдөр          Дугаар А/445          Улаанбаатар хот

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн
196 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сонгинохайрхан дүүргийн 196 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 4 нэр төрлийн нийт 988,829.50 (есөн зуун наян найман мянга найман зуун хорин есөн төгрөг тавин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн 196 дугаар цэцэрлэгийн (Л.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 4 нэр төрлийн 988,829.50 (есөн зуун наян найман мянга найман зуун хорин есөн төгрөг тавин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 25,000.00 (хорин таван мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 7,500.00 (долоон мянга таван зуу) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Сонгинохайрхан дүүргийн 196 дугаар цэцэрлэгийн (Л.Байгалмаа)-т, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ          В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 06 -ны өдрийн А/445 дугаар тушаалын хавсралт

## Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

*Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн 196-р цэцэрлэг*

| д/д | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэгжийн үнэ | Бүгд үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Эвдрэл гэмтэл | ӨХБЗ-ийн дүгнэлт | Байгууллагын үнийн санал | НӨХГ-ын мэргэжилт-ний дүгнэлт | ЭБХХХК-н шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Тавилга, эд хогшил** | | | | | | | | | | | | | |
| 1 | Гал тогооны вандан ширээ | 10 | ширхэг | 1 | 150,352.88 | 150,352.88 | 150,352.88 | 0.00 | Эвдэрсэн, Ашиглах хугацаа дуусч дахин үнэлэгдсэн хугацаа дууссан | актлах | 3,000.00 | 3,000.00 | 3,000.00 |
| 2 | Модон тавиур | 7 | ширхэг | 1 | 200,000.00 | 200,000.00 | 200,000.00 | 0.00 | Эвдэрсэн, Ашиглах хугацаа дуусч дахин үнэлэгдсэн хугацаа дууссан | актлах | 5,000.00 | 5,000.00 | 5,000.00 |
| 3 | Тоглоомын тавиур | 10 | ширхэг | 4 | 127,768.97 | 511,075.88 | 511,075.88 | 0.00 | Эвдэрсэн, Ашиглах хугацаа дуусч дахин үнэлэгдсэн хугацаа дууссан | актлах | 12,000.00 | 12,000.00 | 12,000.00 |
| 4 | Хүүхдийн ширээ | 10 | ширхэг | 1 | 127,400.74 | 127,400.74 | 127,400.74 | 0.00 | Эвдэрсэн, Ашиглах хугацаа дуусч дахин үнэлэгдсэн хугацаа дууссан | актлах | 5,000.00 | 5,000.00 | 5,000.00 |
| **Дүн** | | | | | | **988,829.50** | 988,829.50 | - | | | | | |
| Нийт данснаас хасах хөрөнгийн дүн | | | | 7 | | 988,829.50 | 988,829.50 | - | | | 25,000.00 | **25,000.00** | **25,000.00** |
| Үнээс. Худалдах хөрөнгө | | | | | | 988,829.50 | 988,829.50 | - | | | | | |
| Устгах хөрөнгө | | | | | | | | - | | | | | |
| Татан төвлөрүүлэх хөрөнгө | | | | | | | | - | | | | | |
| Худалдсанаас олох орлого | | | | | | | 25,000.00 | - | | | | | |
| НӨХГ-т төвлөрүүлэх /30%/ | | | | | | | 7,500.00 | - | | | | | |